

Дээрх онцлог ба онцгой нөхцлүүдэд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах талаар сонсогчдоор дипломын ажил бичүүлж удирдаж байгаа бөгөөд судалгааны холбогдох материал, лавлах өгөгдөхүүн зэрэг нэлээд зүйлийг цуглуулсан тул сонирхож буй хүмүүс санал бодлоо солилцож болох юм.



Багш дэд хурандаа Ц.Ганболд.

ХИЛЧИН ШАЛГАГЧ ГЭЖ ХЭН БЭ?

Улсын хилийн боомт газарт, төрийн өмнөөс зүтгэж яваа хянан шалгах үүрэг бүхий хилчнийг "шалгагч" гэдэг. Тэр нь дотроо шалгагч ахлагч, шалгагч офицер гээд бас ялгаатай. Үүрэг нь ч тусдаа. Нэг нь гүйцэтгэгч, нөгөө нь удирдагч.

Улсынхаа нэрийн өмнөөс ирсэн, буцсан зочин гийчидтэй нүүр тулан учирч хэн болохыг нь тодорхойлогч паспорт, баримт бичгийг шалгагчийн тухай олон зүйлийг ярьж болох юм.

Энэ удаа шалгагч-ахлагч ямар үүрэг гүйцэтгэдэг талаар товч өгүүлье. Шалгагч ахлагч нь төрийн албаны тухай хуулинд зааснаар төрийн тусгай албан хаагч гэдэг хэргэм зэрэгт багтдаг.

Хилийн цэргийн хил хамгаалах үйл ажиллагааны нэг хэлбэр болох Шалган нэвтрүүлэх алба /ШНА/ нь зорчигчийн хүчин төгөлдөр баримт бичгээр улсын хил нэвтрүүлэх, хил зөрчигч, зөрчихийг завдагсдыг илрүүлэх зорилгоор тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, хилийн боомтод мөрдөх журмыг сахиулах гэсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ гэсэн хууль эрхийн үндэслэлээр шалгагч нар үүргээ биелүүлж, бас хариуцлага хүлээнэ.

Тийм ч учир шалгагч хүн сонор сэрэмжтэй, гярхай, албаны өндөр дадлагатай, сэргэлэн цовоо, бие бялдрын хөгжил сайтай, хэлний

боловсролтой /5-6 хэл дээр өөрийн орны хууль тогтоомжийг чөлөөтэй тайлбарлаж чаддаг/ байх шаардлагатай бөгөөд олон улсын болон өөрийн орны улсын хил нэвтрэх эрхийн баримт бичгийн загвар /эх/-ыг судалж мэдсэн байх, тэдгээрийн баталгаажсан байх нөхцөл /тамга, гарын үсэг, паспортын бүтэц/-ийг мэдрэх дадлагатай болох, ямар хэл дээр бичигдсэн байх, ихэнх улсын паспортын бичлэг нь англи хэлээр давхар тайлбартай байдгийг мэдэх, паспортын эх загварт ямар зураг, бусад тэмдэглэл байхгүй учир нэмэлт бичлэгүүдийг гараар юмуу, хэвлэлийн ямар аргаар үйлдсэнийг таньж, хуурамч эсэхийг тодруулах зэрэг эхний ээлжинд анхаарал хандуулах ажиллагааг дэс дараалан гүйцэтгэнэ.

Хэрэв хүчин төгөлдөр бус гэж ажиглагдвал /сэжиг төрвөл/ гүнзгийрүүлэн шалгах аргад шилжих, зорчигчийн аялалын зорилго, хаанаас уг баримт бичгийг авсан, Монголд ирэх, дамжин өнгөрөх виз хаанаас авсан, хэн олгосон байх зэргийг зорчигчийн эх хэлээр юмуу, англи хэлээр асуух журмаар лавлаж энэ явцдаа зорчигч өөрөө, паспортыг албан байгууллагаас уу, хувь хүмүүсээс үү, яаж авсныг зайлшгүй тодотгоно.

Эх загварт анхны хэвлэлийн өөрчлөлт орсон эсэх нь шалгагч хүнд жирийн нүдээр үзэхэд, өсгөгч шилний тусламжтайгаар харахад эхний дүгнэлт хийх боломж бий болно. Гараар зориуд өөрчлөх, элдэв нарийн багаж техникийн тусламжтай өөрчлөх мэтийн заль мэх хэрэглэсэн үйлдлүүд даанч олон тохиолдоно.

Зөвхөн өнгөрсөн жилд гэхэд төмөр замын боомт дээр 1000 гаруй бичиг баримтын зөрчлийг шалгагч нар илрүүлсэн байна. Өөрөөр хэлбэл өдөр бүхэн 2-3 хүний баримт бичиг хүчин төгөлдөр бус байжээ гэсэн үг. Зорчигчийн анзааргагүй, баримт бичгээ тулгаж шалгаагүй зөрчил ч их байдаг.

Тамга, гарын үсгээр баталгаажсан эсэхийг шалгах, тулгаж үзэх эх загвар тэр бүр байхгүй байх хүндрэл бий. Виз авсан байдлыг үзэхэд хэдийгээр баталгаатай гарын үсэг байлаа ч хүчин төгөлдөр биш паспортаар Монголын виз авсан /гадаад оронд байгаа дипломат төлөөлөгчийн газраас/ тохиолдол олон гардаг. Эцсийн мөчид тэд виз олгохдоо паспортын бүтцийг сайн мэдэхгүй байсан гэдэг тайлбар ирүүлдэг. Өөрөөр хэлбэл манай шалгагчаас дор дадлага бүхий хүн гадаадад ийм чухал ажил эрхэлж байгаа шүү дээ. Зүй нь боомт газарт дадлага хийсэн хүнээ гадаадад явуулж ажил эрхлүүлж баймаар!

Визийг элдвээр хуурмагласан үйлдлийг зарим хүн компьютерийн тусламжтай хийж байгаа нь шалгагч нарт хугацаа шаардсан үйлдэл болсоор байна. Ийм хэлбэрийн зөрчлийг илрүүлэхэд

бүрэн тоноглогдсон лаборатори боомтуудад хэрэгтэйг ойлгож арга хэмжээ авах цаг болсон гэж үзэж байна.

Дээр дурдсан зөрчлүүдийг илрүүлэхэд шалгагч өөрөө эргэлзэх тохиолдолд удирдаж байгаа офицерт мэдэгдэж гүнзгийрүүлсэн шалгалт хийлгэдэг. Шалгагчид нэг хүнд асуудал бол шалгуулахаар зогсож байгаа тээврийн хэрэгслийн хөдлөх хугацаа хязгаарлагдмал байна. Олон улсын зорчигчийн галт тэрэг, онгоц, машины шалгалтад орох хугацаа, түүнд явж байгаа зорчигчийн тоо олон байх нь шалгалтыг итгэлтэй, чанартай явуулахад хүндрэл учруулдаг. Яарч тэвдсэнээс алдаа гаргах нь ч бий. Энэ нь давхар шалгалтаар тогтоогдоно. Үүний төлөө цалингаа хасуулах нь ч элбэг. Бидний мэдэж байгаагаар бусад оронд энэ ажлыг компьютерийн тусламжтайгаар богино хугацаанд баталгаатай шалгадаг болчихоод байна. Шалгагч хүн зорчигчдыг шалгах явцдаа эрэн сурвалжлагдаж байгаа гадаад, дотоодын 120-180 гаруй хүний нэрсийг тулгаж шалгах давхар үүрэг хүлээдэг. Энэ бас нэг бэрхшээл юм. Нэг хүн зөрчлийг илрүүлэх боломж муу байдгийн учир үүнд оршино. Монголд жилдээ төмөр замаар 90 шахам орноос зорчигч ирж байгаа нь бага тоо биш л дээ.

Шалгагч хүний гурав дахь бэрхшээл нь энэ олон өгөгдөхүүнийг илрүүлэх аргыг бүрэн эзэмших эсэх нь харьцангуй бас л их хугацаа шаарддаг. Хувь хүний боломж, авхаалж самбааг сорьдог ажлын нэг юм. Ирж, буцаж байгаа хүмүүс цөм сайхан санаа өвөрлөж ирдэггүй, тэр дотроо хулгайч, худалч, дээрэмчин, заль мэхтэй "аваргууд" ч яваа. Энэ нь шалгагч хүн олны хараанд явдаг бас нэг эсрэг талын үзүүлэлт юм.

90 оноос хойш орчин үеийн зальтай овжин бизнесменүүд дипломат, албан паспортыг эзэмшиж чаддаг болсонтой холбож үзвэл бүр аюултай. Үүний тод жишээ бол 1998 онд Хятадын 18 иргэн өөрийн улсын паспортыг хуурмагласан. 1999 онд Хятадын 6 иргэн, Япон улсын паспортыг хуурамчаар үйлдэн хил зөрчихийг завдсан явдал юм. Энэ ажиллагаанд монголчууд ч оролцсон нь нотлогдсон билээ. Баримт бичгийн зөрчлөөс үзэхэд шалгаж байгаа нь тухайн тохиолдолд нэг хүн, шалгуулж байгаа нь олуул нийлж маш нарийн зөрчлийг сэдэж хуурамчаар олон үйлдлийг хийсэн байдаг. Зарим хүмүүс энэ чиглэлээр мэргэшиж виз, баримт бичигт засвар хийж мөнгөний төлөө ажиллах болжээ.

Гэтэл шалгагч хүний зайлшгүй мэдэж, ажлаа явуулахад Монгол Улсын нийт 28 хуулийн 93 бүлэг, 780 гаруй заалт үйлчилдэг. Тиймээс шалгагч хүн олон зүйлийг мэдэж байж ажлаа зөрчилгүй хийх

боломжтой болдог юм.

Олон зүйл нуршсаны учир нь шалгагч хүний үүрэг тодорхой, харин ч хөдөлмөрийг нь бодитой үнэлэх талаар өөрчлөлт хийхсэн гэсэн бодлоо хуваалцах зорилготой байлаа. Шалгагч нар хариуцлагатай бөгөөд хүндтэй үүргийг биелүүлэхдээ байнга сэтгэл санааны дарамттай хувцасны зохицолдоо муугаас биеийн эрүүл мэнд нь зарим талаар хохирдог байдлыг тооцож байхсан гэсэн санааг илэрхийлэх гэсэн юм. Шалгалт нь гэрэлтэй, гэрэлгүй, хүйтэн, удаан, шөнө өдрийн аль ч нөхцөлд явагддаг учир төрөл бүрийн нэмэлт хангалтыг хийх, цалин хангамж урамшил нь ч өндөр байх хэрэгтэй. Үүнийг бусад ажилтныг хамааруулахгүйгээр зөвхөн шалгагч нарт зориулж хийвэл сайнсан. Гэтэл шалгагчид үүргээ мэдэхгүй алмайрч явдаг мэтээр "Хил судлал" сэтгүүлд бичжээ. Энэ нь эрдэм номгүйдээ биш, шалгагч хүний нарийн хүнд үүрэг, ажлын байдлыг сайн мэдэхгүйд л байгаа байх. Эцэст нь тэмдэглэхэд цаашид шалгагч нар өөрсдөө бодол саналаа бичээсэй, эрдэмтэдтэй зөвлөлдөөсэй гэж хүсч байна.

"Хил судлал" сэтгүүл гардаг болсноор хилчдийн эрх ашгийг хамгаалах сэдвээр хэлэлцэж, ярилцах боломж нээгдэж байгааг олзуурхаж явдгаа хэлье.



Хурандаа О.Пүрэвжав.